



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шийдэл финанс ББСБ” ХХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргах 12 сарын хугацаатай, жилийн 15 хувийн хүүтэй, нэг бүр нь 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,900 /нэг мянга есөн зуу/ ширхэг хаалттай өрийн бичгийг нэмж бүртгэсүгэй.

2. Хаалттай өрийн бичиг гаргахтай холбогдуулан хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Шийдэл финанс ББСБ” ХХК /Ч.Баатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН